

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/023/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр аймаг
2025 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: "Платиниум прогресс аудит" ХХК
Захирал: Ж.Баяртуул
Утас: 99066015, Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com
Аудитор: Г.Гантуяа
Утас: 99060147, Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviumber@audit.gov.mn

2025.02.17 № 13

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
А.ЗУРГААНЖИН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

422502051

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Боловсролын яамнаас 93.6 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,412,291.52</u>	<u>11,184,591.52</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	583,591.52	8,088,591.52
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	583,591.52	8,088,591.52
3121	Төгрөг	583,591.52	8,088,591.52
31218	Ахмадын сангийн харилцах	583,591.52	8,088,591.52
35	БАРАА МАТЕРИАЛ	3,828,700.00	3,096,000.00
354	Хангамжийн материал	3,828,700.00	3,096,000.00
35410	Бичиг хэргийн материал	941,500.00	526,500.00
35420	Аж ахуйн материал	2,887,200.00	2,569,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>391,396,358.29</u>	<u>689,220,234.34</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	391,396,358.29	689,220,234.34
392	Биет хөрөнгө	390,388,358.29	688,212,234.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	263,446,545.93	263,446,545.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,816,283.71)	(33,207,059.47)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,221,075.00	36,221,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,221,075.00)	(36,221,075.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	178,454,636.00	193,525,331.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41,243,857.05)	(71,378,116.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,384,700.00	23,384,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,837,382.88)	(7,165,373.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	339,748,354.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(20,142,147.09)
393	Биет бус хөрөнгө	1,008,000.00	1,008,000.00
39301	Програм хангамж	1,300,000.00	1,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,300,000.00)	(1,300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,008,000.00	1,008,000.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>395,808,649.81</u>	<u>700,404,825.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>395,808,649.81</u>	<u>700,404,825.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	395,808,649.81	700,404,825.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	251,766,128.90	251,766,128.90
51101	Өмч: - төрийн	251,766,128.90	251,766,128.90
512	Хуримтлагдсан үр дүн	120,942,898.82	425,539,074.87
51210	Өмнөх үеийн үр дүн	91,617,478.87	120,942,898.82
51220	Тайлант үеийн үр дүн	29,325,419.95	304,596,176.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,099,622.09	23,099,622.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>395,808,649.81</u>	<u>700,404,825.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,007,942,242.36	2,007,084,349.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	187,549,781.15	386,032,049.00
120	Нийтлэг татварын бус орлого	187,549,781.15	386,032,049.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	187,549,781.15	386,032,049.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	187,549,781.15	378,032,049.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	820,392,461.21	1,621,052,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	775,289,191.52	1,547,315,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	775,289,191.52	1,547,315,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,103,269.69	73,737,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,520,829.69	60,858,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,582,440.00	12,879,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	894,527,430.88	1,684,092,570.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,527,430.88	1,684,092,570.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,645,218.88	546,330,279.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,756,601.69	362,648,429.63
210101	Үндсэн цалин	103,254,637.07	199,417,101.79
210102	Нэмэгдэл	66,660,629.69	104,524,928.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,705,000.00	26,649,999.84
210104	Урамшуулал	15,136,334.93	32,056,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,345,700.00	44,790,400.00
210201	Тэтгэврийн даатгал	17,235,000.00	30,718,963.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,027,700.00	3,540,523.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,622,120.00	1,730,662.00
210204	Ажилгүйдлийн даатгал	405,580.00	1,730,662.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,055,300.00	7,069,590.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,380,888.00	6,283,856.80
210301	Гэрэл, цахилгаан	301,452.00	382,364.00
210302	Түлш, халаалт	2,689,036.00	3,441,742.80
210303	Цэвэр, бохир ус	122,400.00	191,750.00
210304	Байрны түрээс	2,268,000.00	2,268,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,811,350.00	27,594,850.00
210401	Бичиг хэрэг	4,030,700.00	6,362,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,146,600.00	15,326,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	224,000.00	392,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	341,300.00	334,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,358,200.00	5,178,450.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	48,710,550.00	-
2107	Томилолт, зочны зардал	8,056,000.00	2,943,400.00
210702	Дотоод албан томилолт	8,056,000.00	2,943,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,799,000.00	27,626,272.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	227,800.00	26,411,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,251,900.00	202,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	61,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	344,572.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	9,000.00	35,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	56,200.00	495,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	140,600.00	137,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,495,679.19	74,443,070.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,930,171.15	10,209,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,258,200.00	2,421,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,307,308.04	61,812,570.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	514,882,212.00	1,137,762,291.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	514,338,300.00	1,124,116,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	229,417,200.00	324,288,033.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	284,599,600.00	799,512,867.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,500.00	315,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	543,912.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	543,912.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	13,645,991.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,645,991.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>113,414,811.48</u>	<u>322,991,778.06</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	84,089,391.53	18,395,602.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	84,089,391.53	18,395,602.01
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(84,089,391.53)	(18,395,602.01)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>29,325,419.95</u>	<u>304,596,176.05</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>820,392,461.21</u>	<u>1,629,052,300.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	8,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	8,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	820,392,461.21	1,621,052,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	775,289,191.52	1,547,315,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	775,289,191.52	1,547,315,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,103,269.69	73,737,200.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,520,829.69	60,858,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,582,440.00	12,879,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	819,808,869.69	1,621,547,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	819,808,869.69	1,621,547,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304,926,657.69	483,785,008.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,676,029.69	361,839,582.24
210101	Үндсэн цалин	103,254,637.07	200,006,205.24
210102	Нэмэгдэл	66,660,629.69	110,957,661.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,705,000.00	26,469,554.00
210104	Урамшуулал	15,055,762.93	24,406,162.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,345,700.00	45,599,247.39
210201	Тэтгэврийн даатгал	17,235,000.00	32,030,614.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,027,700.00	3,392,332.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,622,120.00	1,696,016.00
210204	Ажилгүйдлийн даатгал	405,580.00	1,696,016.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,380,888.00	6,399,606.80
210301	Гэрэл, цахилгаан	301,452.00	407,364.00
210302	Түлш, халаалт	2,689,036.00	3,441,742.80
210303	Цэвэр, бохир ус	122,400.00	282,500.00
210304	Байрны түрээс	2,268,000.00	2,268,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,444,600.00	19,289,900.00
210401	Бичиг хэрэг	3,660,200.00	2,184,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,146,600.00	15,326,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	224,000.00	392,100.00
210404	Ном, хэвлэл	69,400.00	68,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	341,300.00	334,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,003,100.00	984,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,900,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	-
210604	Урсгал засвар	900,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	8,056,000.00	2,943,400.00
210702	Дотоод албан томилолт	8,056,000.00	2,943,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,880,000.00	27,647,272.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	308,800.00	26,445,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,251,900.00	202,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	61,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	344,572.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	9,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	56,200.00	495,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	140,600.00	137,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,243,440.00	20,066,000.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,145,240.00	13,007,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,098,200.00	7,058,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	514,882,212.00	1,137,762,291.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	514,338,300.00	1,124,116,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	229,417,200.00	324,288,033.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	284,599,600.00	799,512,867.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,500.00	315,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	543,912.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	543,912.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	13,645,991.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,645,991.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>583,591.52</u>	<u>7,505,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	583,591.52	7,505,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	583,591.52
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	583,591.52	8,088,591.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	91,617,478.87	366,483,229.86
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	91,617,478.87	366,483,229.86
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	29,325,419.95	29,325,419.95
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	120,942,898.82	395,808,649.81
9	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	120,942,898.82	395,808,649.81
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	120,942,898.82	395,808,649.81
12	Үндсэн хөрөнгийн дахин	-	-	-	-

	үнэлгээний өсөлт, бууралт				
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	304,596,176.05	304,596,176.05
17	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	425,539,074.87	700,404,825.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,547,315,100.00	1,536,764,504.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,547,315,100.00	1,536,764,504.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,657,300.00	412,648,204.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	345,777,800.00	342,351,582.24
210101	Үндсэн цалин	216,848,100.00	200,006,205.24
210102	Нэмэгдэл	98,935,700.00	91,469,661.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,819,700.00	26,469,554.00
210104	Урамшуулал	17,174,300.00	24,406,162.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,222,100.00	42,689,443.14
210201	Тэтгэврийн даатгал	30,698,100.00	29,541,325.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,131,000.00	3,287,204.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,565,500.00	1,643,452.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,565,500.00	1,643,452.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,262,000.00	6,574,010.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,216,100.00	6,399,606.80
210301	Гэрэл, цахилгаан	1,128,700.00	407,364.00
210302	Түлш, халаалт	4,658,500.00	3,441,742.80
210303	Цэвэр, бохир ус	2,425,100.00	282,500.00
210304	Байрны түрээс	3,003,800.00	2,268,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,504,000.00	7,503,900.00
210401	Бичиг хэрэг	867,400.00	867,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,857,600.00	4,857,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	392,100.00	392,100.00
210404	Ном, хэвлэл	68,100.00	68,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	334,800.00	334,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	984,000.00	984,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,033,400.00	1,033,400.00
210702	Дотоод албан томилолт	1,033,400.00	1,033,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,620,500.00	1,406,272.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	302,900.00	204,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	202,000.00	202,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,800.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,400.00	344,572.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,100.00	495,100.00
210807	Газрын төлбөр	4,400.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	137,900.00	137,900.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,283,400.00	11,264,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,225,100.00	4,205,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,058,300.00	7,058,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,125,657,800.00	1,124,116,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,125,657,800.00	1,124,116,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	324,406,800.00	324,288,033.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	800,935,600.00	799,512,867.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	315,400.00	315,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,547,315,100.00	1,536,764,504.18
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,547,315,100.00	1,536,764,504.18
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,547,315,100.00	1,536,764,504.18
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,737,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,737,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,737,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,488,000.00
210102	Нэмэгдэл	19,488,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,909,804.25
210201	Тэтгэврийн даатгал	2,489,289.00
210202	Тэтгэмжийн даатгал	105,128.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	52,564.00
210204	Ажилгүйдлийн даатгал	52,564.00
210205	Эрүүл мэндийн даатгал	210,259.25
2104	Хангамж, бараа материалын зардал	11,786,000.00
210401	Бичиг хэрэг	1,316,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,469,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,910,000.00
210702	Дотоод албан томилолт	1,910,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,241,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,241,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,307,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,307,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,095,395.75
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,095,395.75
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	73,737,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	73,737,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,858,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,879,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,103.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 6,558.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 6,140.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,405.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Газрын дарга, төсвийн мэргэжилтэн нарын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон боловч Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн Б/39 дүгээр тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Өөрчлөлтгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр хууль тогтоомж зөрчиж, хэм хэмжээ хэтрүүлэн даргад 2,899.5 мянга, төсвийн мэргэжилтэнд 2,206.5 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон, зардлын ангилал зөрчин төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар гарсан зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь “Хуульд тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3.3-т “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь хэсгийг тус тус зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид заасан хэм хэмжээ хэтрүүлж давхардуулан олгосон урамшууллыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2 Тайлант онд шилдэг ажилтнаар нэг албан хаагчийг шалгаруулж, зардлын ангилал зөрчиж, цалингийн зардлаас 1,452,000.00 (Нэг сая дөрвөн зуун тавин хоёр мянган) төгрөгийн урамшуулал олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомж зөрчин шилдэг ажилтны урамшуулалд олгосон зардлыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1 Төсвийн мэргэжилтэнд нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 1,034.0 мянган төгрөгийн цалин олгосон зөрчил дахин давтагдан гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам” 2.2. “Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон зөрчлийг арилган, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2.2 Газрын дарга, төсвийн мэргэжилтэн нарын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон боловч Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн Б/39 дүгээр тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өөрчлөлтгүй” дүгнүүлсэн гэх хууль тогтоомжид заагаагүй үндэслэлээр даргад 2,899.5 мянган төгрөг, төсвийн мэргэжилтэнд 2,206.5 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг давхардуулан, зардлын ангилал зөрчин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь “Хуульд тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь хэсгийг тус тус зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

1. Урьд оны үр дүнгийн урамшуулалтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт Урьд оны санхүүгийн тайланд цалингийн өглөггүй тайлагнасан боловч Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/158 дугаар тушаалаар газрын даргад 2023 оны үр дүнгийн урамшууллын 1,405.6 мянган төгрөгийг төсвийн жил дамнуулан олгож тайлант оны зардлыг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйл. 26.1 дэх "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккурэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", 43 дугаар зүйлийн 43.5 дахь "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн жил дамжуулан тайлант оны зардлыг нэмэгдүүлэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/ сая төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Боловсролын газар	1	5.1	1	5.1									
Боловсролын газар	1	1.5	1	1.5									
Боловсролын газар	1	1.0			1	1.0							
Боловсролын газар	1	5.1			1	5.1							
Боловсролын газар	1	1.4					1	1.4					
Дүн	5	14.1	2	6.6	2	6.1	1	1.4					

